



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 25 өдөр

Дугаар А/377

Номгон


Г Согтууруулах ундаа худалдах тусгай
зөвшөөрлийн хугацаа сунгах тухай

Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.3, 15.4, 16 дугаар зүйлийн 16.1, Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1, 5.3 дугаар зүйлийн 1, 5.5 дугаар зүйлийн 10 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой асуудлаар дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн дүгнэлтийн дагуу Баянхонгор сумын “Оюун Номин Хорол” ХХК-ий Тамсаг, “Шар бүрдний эх” ХХК-ний Шар бүрд хүнсний дэлгүүрийн тусгай зөвшөөрлийн хугацааг 2024 оны 06 дугаар сарын 19-ний өдрөөс 2029 оны 06 дугаар сарын 19-ний өдрийг хүртэл 5 жилийн хугацаагаар сунгасугай.

2.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль, Зөвшөөрлийн тухай хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан журам, шийдвэр, цагийн хуваарийг чанд мөрдөж, иргэдэд стандартын шаардлага хангасан хүнсний бүтээгдэхүүн худалдаалахыг аж ахуйн нэгжийн захирал Б.Оюун, Ч.Бямбадорж нарт, холбогдох хууль, дүрэм, журмыг хэрэгжүүлэн ажиллаж байгаад хяналт тавьж ажиллахыг аймгийн Цагдаагийн газар (Б.Мөнхбаяр) нарт тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын тамгын газрын Хууль,эрх зүйн хэлтэс (Д.Сарангарав)-т даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

• 824010946